

АӨСҮТ-ийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар, аюулгүй байдлын албаны зорилго нь чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, нотолгоонд тулгуурлан өвчтөн болон хүн амын хэрэгцээ, бүрэн эрхэд нийцүүлж, өвчтөний гэр бүл болон хувь хүний үнэт зүйл, итгэл шүтлэгийг хүндэтгэн, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн, чанарыг тасралтгүй сайжруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.

Зорилтууд

- Чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эмчилгээ, оношилгооны стандарт, эмнэлзүйн удирдамж, эмнэлгийн технологийн мөрдөлтийг эрчимжүүлэн, чанарын үндсэн үзүүлэлтийг сайжруулах
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлэх
- Эрсдэлийн удирдлагын менежментийн тасралтгүй үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнг тооцох
- Үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган, тусламж үйлчилгээний халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх
- Хувь хүн болон нийт хүн амд ЭМ-ийн тусламж үйлчилгээг эрүүл мэндэд нь ээлтэй нөлөө өгөхүйц, өнөөгийн мэргэжлийн түвшинд үзүүлэх
- Шилдэг нотолгоонд тулгуурлан, өвчтөн болон хүн амын хэрэгцээ, бүрэн эрхэд нийцүүлж, өвчтөний гэр бүл болон хувь хүний үнэт зүйл, итгэл шүтлэгийг хүндэтгэн, хүртээмжтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай ЭМ-ийн тусламж үйлчилгээг үзүүлснээр биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хангах.

Үйл ажиллагааны чиглэл

- 2020 оны 04 сарын 17-ний өдрийн Б/69 тоот тушаалаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны бүтэц зохион байгуулалт, ажиллах журам”-ыг батлуулан мөрдөн ажиллаж байна.
- Одоо ЭМТҮЧАБАлба нь албаны дарга, чанар, аюулгүй байдлын менежер гэсэн 2 орон тооны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
 - Үйлчилгээний чанарын үнэлгээ. Магадлан итгэмжлэлийн шаардлагын явцын хяналт, байгууллагын үйл ажиллагааны чанартай холбоотой үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, ижил мэргэжилтний үзлэг, өөрийгөө үнэлэх, үйлчлүүлэгчдийн болон ажиллагсдын сэтгэл ханамжийг судлах, чанарын хяналт үнэлгээний бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх чанарын дотоод хяналтын тогтолцоог зохион байгуулах, дүн шинжилгээ хийх.

- Чанарын сайжруулалт. Чанарын үнэлгээгээр доголдолтой асуудлуудыг илрүүлэх, сайжруулах арга замыг тодорхойлж, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, ажилтнуудыг идэвхтэй оролцуулах,
- Тусламж үйлчилгээний чанарын зохицуулалт/баталгаажуулалт. Чанарын удирдлагын асуудлаар байгууллагын бодлого, дүрэм, журам гаргах, эмчилгээ оношлогооны стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн мөрдөлтийг сайжруулах, эмнэлгийн анхан шатны бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах, үйлчлүүлэгчийн гомдол, саналыг хүлээж авах, хянан шалгах, эмнэлгийн дотоод аудитыг төлөвлөгөөний дагуу хийх.
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, MNS ISO 9001:2016 стандартын биелэлтийг байнга сайжруулах

Холбогдох эрх зүйн баримтууд

- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж А136
- ЭМС-ын 2014 оны 55 дугаар тушаал "Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөгжлийн бодлого батлах тухай"
- ЭМС-ын 2021 оны А578 дугаар тушаал "Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай "
- Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын баталсан 2019 оны 12 сарын 12 ны өдрийн 116/А565 дугаар тушаал "Чанар, аюулгүй байдлын албаны дүрэм батлах тухай"
- ЭМС-ын 2019 оны 12 сарын 12 ны өдрийн А/566 дугаар тушаал "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай"
- ЭМС-ын 2017 оны А/514 дүгээр тушаал "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл төлөвлөгөө батлах тухай"
- ЭМС-ын 2022 оны А/50 дүгээр тушаал "Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам"
- ЭМС-ын 2022 оны А/352 дүгээр тушаал "Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам"